

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/013/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn  Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn  Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn  Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70982112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 507  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ ТОСГОНЫ  
ЗАХИРАГЧ Д.АЛТАННАРАА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Захирагчийн харьяа Захирагчийн ажлын албад холбогдох 18,363.4 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн санд холбогдох 33,958.0 мянган төгрөгийн, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хамаарах 17,928.2 мянган төгрөгийн, нийт 70,249.5 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тосгоны Захирагчийн ажлын алба халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,654.6 мянган төгрөгөөр илүү төлсөн,
- Төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилж 4,189.3 мянган төгрөгийн, Санхүүгийн албаны даргын албан

үүргийг нягтлан бодогчид хавсруулж цалингийн 40 хувь буюу 6,519.4 мянган төгрөгийн, нийт 10,708.7 мянган төгрөгийн цалин олгосон,

- Шилэн дансны цахим хуудсанд Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт 33,958.0 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй,
- Тосгоны Захирагч нь 2025 оны төсвийн тодотголыг боловсруулахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 17,928.2 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Эрчим хүчний сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай" тушаалын 1 в-д Сүхбаатар, Хэнтий, Ховд, Говьсүмбэр аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг 5 дугаар сарын 01-ний өдрөөр",
- ✓ Төрийн албаны тухай хуулийн 43.3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараах журмаар түр орлон гүйцэтгүүлнэ: ...", 43.6. "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно",
- ✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор,"
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд аймгийн төсвөөс 325,586.3 мянган төгрөгийн дэмжлэг авч, 612,205.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,017,294.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 101,884.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 4,506.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,600.0 мянган төгрөгийг зарцуулж, 906.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

#### **Аудитын гол асуудал**

Аудитаар тосгоны хэмжээнд нийт 150,774.8 төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс 77,667.7 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 1,920.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 71,187.1 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Орон нутгийн хөгжлийн сангаар 91,523.9 мянган төгрөгийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2 ажлыг 32,958.5 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, төв талбайн тохижилтын 1 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Тосгоны төсвийн орлого зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		506,611.77	679,771.3
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	439,369.18	579,208.8
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	184.84	906.33
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	67,057.75	99,656.18
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,360,896.58	1,465,548.52
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,360,896.58	1,465,548.52
7	1.2.2.02 Биет хөрөнгө		1,304,501.58	1,409,168.52
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	56,395	56,380
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,867,508.35	2,145,319.82
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	8,872.75
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	8,872.75
12	2.1.1.03 Өглөг		0.0	8,872.75
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,867,508.35	2,136,447.07
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		1,867,508.35	2,136,447.07
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		150,057.83	150,057.83
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		1,610,618.27	1,879,556.99
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		106,832.24	106,832.24
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,867,508.35	2,145,319.82

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,357,602.2	1,373,364.85
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		261,831.59	659,280.33
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		168,872.96	348,968.24
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		168,872.96	348,968.24
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		65,182.76	290,743.08
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		27,775.87	19,569.02
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	404,738.93	714,084.52
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	326,902.63
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		691,031.69	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	664,091.06	1,129,593.31
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		664,091.06	1,129,593.31
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		652,491.06	1,121,343.31
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		242,662	340,566.5

14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		31,070.8	42,301.28
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		199,278.77	452,160.54
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		30,035.44	23,353.81
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		1,150	0.0
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		17,088.39	31,281.74
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		7,035	7,330
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,194.79	1,874.21
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		121,975.88	222,475.24
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,600	8,250
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		693,511.14	243,771.53
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		104,141	0.0
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-104,141	0.0
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		589,370.14	243,771.53

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	953,391.75	1,083,696.86
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	261,831.59	659,280.33
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	168,872.96	348,968.24
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	65,182.76	290,743.08
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	27,775.87	19,569.02
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,952.49	12,544.28
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	13,823.38	7,024.74
8	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	528.47	424,416.53
9	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	528.47	2,800
10	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	330,092.63
11	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	91,523.9
12	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	691,031.69	0.0
13	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,182.4	910,898.74
14	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	545,182.4	910,898.74
15	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	533,482.4	901,577.41
16	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,561.72	340,781.66
17	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,360.24	42,301.28
18	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198,271.62	451,083.98
19	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	24,561.44	14,291.3
20	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	200	300
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	16,599.09	25,327.85

22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	6,935	7,330
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,410.79	7,760.95
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	8,582.5	12,400.4
25	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,700	9,321.33
26	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	408,209.35	172,798.12
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	104,141	32,958.5
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	104,141	32,958.5
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	104,141	32,958.5
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-104,141	-32,958.5
31	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	304,068.35	139,839.62
32	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	135,300.83	439,369.18
33	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	439,369.18	579,208.8

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,278,138.21		1,278,138.21
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,278,138.21		1,278,138.21
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	589,370.14		589,370.14
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,867,508.35		1,867,508.35
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,867,508.35		1,867,508.35
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,167.19		25,167.19
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,892,675.53		1,892,675.53
8	1.7 Тайлант үеийн үр дүн	243,771.53		243,771.53
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,136,447.07		2,136,447.07

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,693,336.7	1,579,860.5
11	3.1.01.1.1 Татварын орлого	266,950.0	659,280.3
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	193,500.0	348,968.2
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	193,500.0	348,968.2

<b>110001</b>	<b>3.1.01.1.1.1.1.01</b>	<b>Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого</b>	<b>180,000.0</b>	<b>328,216.4</b>
110002	3.1.01.1.1.1.1.02	Үйл ажиллагааны орлого	5,000.0	6,067.7
110003	3.1.01.1.1.1.1.03	Хөрөнгийн орлого	4,300.0	4,127.0
110004	3.1.01.1.1.1.1.04	Хөрөнгө борлуулсны орлого	4,200.0	10,557.1
<b>113</b>	<b>3.1.01.1.1.3</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>61,100.0</b>	<b>290,743.1</b>
113001	3.1.01.1.1.3.1	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	60,000.0	281,868.4
113002	3.1.01.1.1.3.2	Бууны албан татвар	1,100.0	1,630.0
113004	3.1.01.1.1.3.4	Малд ногдуулах албан татвар	-	7,244.7
<b>118</b>	<b>3.1.01.1.1.8</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>12,350.0</b>	<b>19,569.0</b>
1180	3.1.01.1.1.8.1	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,500.0	12,544.3
118001	3.1.01.1.1.8.1.01	Улсын тэмдэгтийн хураамж	200.0	1,334.0
118009	3.1.01.1.1.8.1.08	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	11,300.0	11,210.3
<b>1181</b>	<b>3.1.01.1.1.8.2</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>850.0</b>	<b>7,024.7</b>
118101	3.1.01.1.1.8.2.01	Газрын төлбөр	850.0	7,024.7
<b>12</b>	<b>3.1.01.1.2</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,426,386.7</b>	<b>920,580.2</b>
120	3.1.01.1.2.1	Нийтлэг татварын бус орлого	1,000.0	2,800.0
120003	3.1.01.1.2.1.3	Торгуулийн орлого	1,000.0	2,800.0
<b>122</b>	<b>3.1.01.1.2.3</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,333,862.8</b>	<b>826,256.3</b>
122003	3.1.01.1.2.3.3	Аймаг нийслэлээс авсан татаас	325,586.3	325,586.3
122005	3.1.01.1.2.3.5	Төсвөөс санхүүжих	1,008,276.5	500,670.0
<b>123</b>	<b>3.1.01.1.2.4</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>91,523.9</b>	<b>91,523.9</b>
123002	3.1.01.1.2.4.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	91,523.9	91,523.9
<b>II</b>	<b>3.1.01.2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,099,800.4</b>	<b>1,854,761.1</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,008,276.5</b>	<b>1,821,802.6</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>998,443.5</b>	<b>897,977.4</b>
<b>2101</b>	<b>3.1.01.2.1.1.1</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>365,284.7</b>	<b>340,781.7</b>
210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	261,960.3	197,865.5
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	51,885.6	115,802.8
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	3,960.0	11,995.0
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	18,000.0	1,374.2
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	29,478.8	13,744.2
<b>2102</b>	<b>3.1.01.2.1.1.2</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,035.5</b>	<b>42,301.3</b>
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	34,024.2	28,436.9
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	4,002.8	3,313.0
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	2,001.4	2,164.5
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	2,001.4	1,632.2

210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	8,005.7	6,754.6
<b>2103</b>	<b>3.1.01.2.1.1.3</b>	<b>Байр ашиглалттай холбоотой</b>	<b>479,913.9</b>	<b>451,084.0</b>
	<b>тогтмол зардал</b>			
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	65,196.2	40,144.4
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	408,717.7	398,558.6
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	6,000.0	12,381.0
<b>2104</b>	<b>3.1.01.2.1.1.4</b>	<b>Хангамж, бараа материалын</b>	<b>16,092.0</b>	<b>14,291.3</b>
	<b>зардал</b>			
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	2,500.0	2,317.3
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	8,000.0	6,984.5
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,092.0	3,740.0
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550.0	339.0
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.0	910.5
<b>2105</b>	<b>3.1.01.2.1.1.5</b>	<b>Нормативт зардал</b>	<b>900.0</b>	<b>300.0</b>
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	900.0	300.0
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	48,125.2	25,327.9
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	12,585.2	769.0
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	540.0	714.9
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	35,000.0	23,844.0
<b>2107</b>	<b>3.1.01.2.1.1.7</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,000.0</b>	<b>7,330.0</b>
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	8,000.0	7,330.0
<b>2108</b>	<b>3.1.01.2.1.1.8</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,392.1</b>	<b>7,760.9</b>
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,132.9	7,385.9
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324.2	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	550.0	-
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	250.0	149.0
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145.0	-
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440.0	176.0
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	550.0	50.0
<b>2109</b>	<b>3.1.01.2.1.1.9</b>	<b>Бараа үйлчилгээний бусад</b>	<b>14,700.1</b>	<b>8,800.4</b>
	<b>зардал</b>			
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	13,750.1	8,174.4
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950.0	626.0
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,833.0</b>	<b>923,825.2</b>
<b>2131</b>	<b>3.1.01.2.1.4.1</b>	<b>Засгийн газрын урсгал</b>	<b>-</b>	<b>915,410.2</b>
	<b>шилжүүлэг</b>			
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	915,410.2
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	9,833.0	8,415.0

213205	3.1.01.2.1.4.2.04	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,250.0	8,250.0
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,583.0	165.0
<b>22</b>	<b>3.1.01.2.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>91,523.9</b>	<b>32,958.5</b>
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	91,523.9	32,958.5
<b>8</b>	<b>3.1.01</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>593,536.3</b>	<b>274,900.6</b>
<b>9</b>	<b>3.1</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>593,536.3</b>
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	593,536.3
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	433,447.0
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	573,286.6
<b>6</b>	<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>31</b>	<b>31</b>
<b>61</b>	<b>6.1</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	6.1.01	Төсвийн байгууллага	1	1
610002	6.1.02	Төсвөөс гадуур байгууллага	-	
<b>62</b>	<b>6.2</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>15</b>	<b>14</b>
620001	6.2.01	Удирдах ажилтан	1	1
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	7	8
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	3	4
620004	6.2.04	Гэрээт ажилтан	4	1
<b>65</b>	<b>6.5</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>15</b>	<b>14</b>
650001	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5
650009	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	8
650011	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4,506.3</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,506.3</b>
<b>122</b>	<b>1.1.1.1.1.1 Тусламжийн орлого</b>	<b>4,506.3</b>
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	4,506.3
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	4,506.3
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,506.3
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000.0
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,600.0</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,600.0</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,600.0</b>
<b>2109</b>	<b>1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,600.0</b>
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	3,600.0
<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>906.3</b>
<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-
		906.3

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Өлзийт тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар Захирагчийн ажлын албаны санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

#### **3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 62,159.3 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 9,837.9 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup>г санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 52,321.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

##### **Захирагчийн ажлын алба:**

1. Санхүүгийн тайланд санхүүжилтийн орлого болон төвлөрүүлсэн шилжүүлгийг 820.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залруулав.
2. Захирагчийн ажлын алба нь халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримталж ажиллаагүй, халаалтын төлбөрийг 7,645.6 мянган төгрөгөөр илүү төлсөн. Энэ нь Эрчим хүчний сайдын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай” тушаалын 1.в-д Сүхбаатар, Хэнтий, Ховд, Говьсүмбэр аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг 5 дугаар сарын 01-ний өдрөөр” гэснийг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.
3. Захирагчийн ажлын алба нь төрийн захиргааны албан тушаал болох Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр шаардлага хангаагүй иргэнийг томилж 4,189.3 мянган төгрөгийн, Санхүүгийн албаны даргын албан үүргийг нягтлан бодогчид хавсруулан цалингийн 40 хувь 6,519.4 мянган төгрөгийн, нийт 10,708.7 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43.3."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ: ...", 43.6. "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

##### **ОНХС:**

1. Малын тоо толгойн албан татварын орлогын 9,017.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд буруу илэрхийлснийг залруулав.
2. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудсанд Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт 33,958.0 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### **3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20,449.0 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс 17,591.4 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,920.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 937.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **Соёлын төв:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг 1,900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлж, 13,176.3 мянган төгрөгийн төвлөрүүлсэн шилжүүлэг, 4,240.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг тохируулаагүй алдааг залруулав.
2. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 1,920.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **Хүүхдийн цэцэрлэг:**

1. Тайлант онд мэдээллийн технологийн зардал гэсэн эдийн засгийн ангиллын зардлаас зориулалт бусаар зарцуулж зардлын ангилал зөрчиж, 937.6 мянган төгрөгөөр компьютер хэрэгсэл худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### **Эрүүл мэндийн төв:**

1. Санхүүгийн тайланд 175.1 мянган төгрөгийн авлагыг хасах дүнтэй өглөгөөр бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

**Ерөнхий боловсролын сургууль:** Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

### **3.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын талаар:**

Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 68,166.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 50,238.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 17,928.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Замд яваа цалин хөлс түүнтэй адилтгах хөрөнгийн орлогын 50,000.0 мянган төгрөг, хөрөнгийн орлогын 238.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.
2. Тосгоны Захирагч нь 2025 оны төсвийн тодотголыг боловсруулахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 17,928.2 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗАА	1	820.1			1	820.1	1	820.1				
ОНХС	1	9,017.8			1	9,017.8	1	9,017.8				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>9837.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>9837.9</b>	<b>2</b>	<b>9837.9</b>				
ЭМТ	1	175.1			1	175.1	1	175.1				
Соёлын төв	1	17,416.3			1	17,416.3	1	17,416.3				
<b>УТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>17,591.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>17,591.4</b>	<b>2</b>	<b>17,591.4</b>				
ТТЗ	1	50,238.4	1	50,238.4			1	50,238.4				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>77,667.7</b>	<b>1</b>	<b>50,238.4</b>	<b>4</b>	<b>27,429.3</b>	<b>5</b>	<b>77,667.7</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗАА	1	7,654.6			1	7,654.6						
ЗАА	1	10,708.7			1	10,708.7						
ОНХС	1	33,958.0			1	33,958.0						
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>3</b>	<b>52,321.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>52,321.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Соёлын төв	1	1,920.0	1	1,920.0								
Цэцэрлэг	1	937.6			1	937.6						
<b>УТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>2,857.6</b>	<b>1</b>	<b>1,920.0</b>	<b>1</b>	<b>937.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
ТТЗ	1	17,928.2			1	17,928.2						
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>73,107.1</b>	<b>1</b>	<b>1,920.0</b>	<b>5</b>	<b>71,187.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 281-А2370447  
ХЭА-2026/013/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Өлзийт тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дагаах зөрчил илэрлээ. Үүнд:

Тосгоны Захирагч нь 2025 оны төсвийн тодотголыг боловсруулахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл 17,928,160.00 (арван долоон сая есөн зуун хорин найм нэг зуун жаран) төгрөгийг бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4. "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өлзийт тосгоны захирагч Д.Алтаннараа-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Н.ТУЯА